



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/196

Бат-Өлзий сум

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт Г  
түр шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газраас Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 2023 оны 10 дугаар сарын 05-аас 2023 оны 10 дугаар сарын 06-ний өдрүүдэд зохион байгуулагдах тул сумын Онцгой комисс, Мэргэжлийн ангийг энэ хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт түр шилжүүлсүгэй.

2. Бат-Өлзий суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнс, барааны дэлгүүр, шатахуун түгээх станцуудын үйл ажиллагааг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 12,00 цагаас 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 24.00 цаг хүртэл түр хязгаарласугай.

3. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, Онцгой комисс, Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангуулж, бүрэн хамруулахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул), Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ), байгууллагуудын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН